



2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр

"ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ БАТЛАХ ТУХАЙ" УЛСЫН ИХ ХУРЛЫН 1999 ОНЫ 27 ДУГААР ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Өргөн хэрэглээний бүтээгдэхүүн болох АИ-92 шатахууны хил үнийг 2022 оны 5 дугаар сараас хойш 705 ам.доллараар тогтворжуулж жижиглэн борлуулалтын үнийг литр тутамд 2390 төгрөгөөр 2025 оны 6 дугаар сар хүртэл тогтворжуулсан. 2025 оны 6 дугаар сараас эхлэн тус бүтээгдэхүүний үнэ 200 төгрөгөөр нэмэгдсэн. Үнэ нэмэгдэх шалтгаан нь цалингийн доод хэмжээг 20 орчим хувиар нэмэгдүүлсэн, эрчим хүчний зардал 50 хувиар өссөн, халаалт, дулааны үнэ 30 хувиар өссөн, төмөр замын тээврийн өртөг 53 хувиар өссөн нь салбарын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг огцом нэмэгдүүлсэнд оршиж байна. Мөн 2026 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн тухайн бүтээгдэхүүнд Гаалийн албан татвар 5 хувиар ногдуулж эхэлснээр тонн тутамд өртгийг 125,000 төгрөгөөр өсгөж АИ-92 шатахууны үнэ нэмэгдэх нөхцөл бүрдээд байна. Иймд Гаалийн албан татварын хувь хэмжээг "0" хувиар тогтоох зайлшгүй шаардлага тулгараад байна.

Иймд ард иргэдийн өргөн хэрэглээний газрын тосны бүтээгдэхүүн АИ-92 автобензинийн үнийн өсөлтийг бууруулах, тогтворжуулах зорилгоор "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай тогтоолын төслийг боловсруулна.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

УИХ-ын 27 дугаар тогтоолд¹ нэмэлт оруулах тухай тогтоолын төсөл үндсэн ганц заалттай байх бөгөөд Монгол Улсын эдийн засаг, нийгэм, инфляцыг тодорхойлогч хэрэглээний сагсанд томоохон хувь эзэлдэг газрын тосны

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1999 он, №27

бүтээгдэхүүн АИ-92 автобензинийн гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох эрхийг Засгийн газарт олгох юм.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

УИХ-ын тогтоолын төсөл батлагдсанаар иргэдийн амьдралд хамгийн том нөлөө үзүүлдэг газрын тосны бүтээгдэхүүний үнэ өсөхөөс сэргийлж, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах эерэг үр дагавар бий болно.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

-oOo-